

Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар
олгох журамд нэмэлт, өөрчлөлт

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1/ Хоёрдугаар зүйл:

“...2.2.7...” дахь заалтын “солилт гэсний дараа хадгалах” гэж нэмэх;

2/ Гуравдугаар зүйл:

3.4.2 дахь заалтын “хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ” гэснийг хасах;

3/ Дөрөвдүгээр зүйл:

4.2.5 дахь заалтыг “автотээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлж буй болон шилжүүлэн авч байгаа иргэн биечлэн ирээгүй тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэн гэрээ, хэлцэл Монгол Улсын Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ” гэж өөрчлөн найруулах;

4/ Долоодугаар зүйл:

“...7.11...” дэх заалтын дараа “7.12 автотээврийн хэрэгслийн бүртгэлээс түр хасах, бүртгэлийг сэргээх” гэж шинээр нэмэх;

“7.12.1 тээврийн хэрэгсэл өмчлөгчийн зүгээс энэхүү журмын 12 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг бүртгэлээс түр хасаж болно” гэж шинээр нэмэх;

“7.12.2 өмчлөгч зөрчлөө арилгасны дараа тухайн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг буцаан сэргээнэ” гэж шинээр нэмэх;

4/ Есдүгээр зүйл:

“...9.1...” дэх заалтыг “Улсын бүртгэлийн дугаарыг өөрчилж, сольсон тохиолдолд өмчлөгч хүсэлт гаргаагүй бол өмнөх улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг хураан авч, устгалд оруулна” гэж өөрчлөн найруулах;

Есдүгээр зүйлийн “солилт гэсний дараа хадгалах” гэж нэмэх;

“...9.9...” дахь заалтын дараа “9.10-д автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг хадгалах тохиолдолд иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ” гэж шинээр нэмэх;

“9.10.1 автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг хадгалуулах хүсэлт” гэж;

“9.10.2 автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг өөрийн эзэмшилд байгааг нотлох баримт” гэж;

“9.10.3 Энэхүү журмын 3.3.2, 3.3.6, 3.3.7, 4.2.3, 4.2.4-т заасан баримт бичиг” гэж;

“...9.9...” дэх заалтын дараа “9.11-д автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг хадгалах тохиолдолд хуулийн этгээд дараах баримт бичгийг бүрдүүлнэ” Үүнд:

“9.11.1 автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг хадгалуулах хүсэлт” гэж;

“9.11.2 автотээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг өөрийн эзэмшилд байгааг нотлох баримт” гэж;

“9.11.3 Энэхүү журмын 3.3.6, 3.3.7, 3.4.2, 4.2.3, 4.2.4-т заасан баримт бичиг” гэж;

5/ Аравдугаар зүйл:

“10.1.6 дахь заалтыг автотээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлж буй болон шилжүүлэн авч байгаа өмчлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч биечлэн ирээгүй” гэж өөрчлөн найруулах;

“10.1.9. дэх заалтын дараа 10.1.10 “олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр төлөөгүй” гэж шинээр нэмэх;

“Автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хэсгийн “10.1.10” дахь гэснийг “...10.1.11...” дэх гэж өөрчилсүгэй.

6/ Арван нэгдүгээр зүйл:

“...11.6...” дахь заалтын дараа “11.7 бүртгэлийн байгууллага нь өмчлөгчийн хүсэлт болон холбогдох баримт, мэдээллийг үндэслэн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг залруулах, шинэчлэх ажлыг хийнэ” гэж шинээр нэмэх;

7/ Арван гуравдугаар зүйл:

“...13.10...” дахь заалтын дараа “13.11. цахим хүсэлт нь цахим гарын үсгийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд иргэн хуулийн этгээдийн санаатай болон санамсаргүй байдлаас үүссэн аливаа эрсдэлийг бүртгэлийн байгууллага хариуцахгүй болно” гэж шинээр нэмэх;

